



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/302

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн
авах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэн нийлүүлэгдсэн нийт 72,211,111.12 (далан хоёр сая хоёр зуун арван нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг арван хоёр мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн “Гурванцүүр” Өрхийн эрүүл мэндийн төв (З.Сарантуяа)-д, Сонгинохайрхан дүүргийн “Буянт Манал” Өрхийн эрүүл мэндийн төв (Э.Хулан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201447



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
03 дугаар... сарын 5-ны өдрийн
... А.302... үүрэг... захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэр-лэсэн он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Суудлын автомашин	Тоёота Приус-41	ZVW413221187	96-60 УНХ	2012	36,105,555.56	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Сонгинохайрхан дүүргийн "Гурванцүүр" ӨЭМТ
2	Суудлын автомашин	Тоёота Приус-41	ZVW413284439	34-01 УАУ	2013	36,105,555.56	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Сонгинохайрхан дүүргийн "Буянт Манал" ӨЭМТ
Нийт дүн						72,211,111.12		